



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/НЗ

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV Хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 14/01 тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол хүн сансарт ниссэний 42 жилийн ой, Булганчуудын бахархлын өдрийг тохиолдуулан гүйлтийн спортыг хөгжүүлэх, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор “Сансар 2023” марафон тэмцээнийг зохион байгуулсугай.

2. “Сансар 2023” марафон тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг Биеийн тамир спортыг, хөгжүүлэх хөтөлбөрийн зардлаас 5,020,000 (таван сая хорин мянга) төгрөг, 4,980,000 (дөрвөн сая есөн зуун наян мянга) төгрөгийг Өсвөрийн шигшээ багийг бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас тус тус санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА, Б.АРИУН-ЭРДЭНЭ

